

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
“АЛСЫН ХАРАА-2050”-Д ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН БОДЛОГЫН ЗОРИЛТ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

2025.08.30-ны байдлаар

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааны 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх урьдчилсан гүйцэтгэл, үр дүнд Засгийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээг хийж гүйцэтгэв.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Эрчим хүчний яамны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээ байна. Үүнээс 9.3.36. Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн заалтыг Улсын Их Хурлаас 2021.12.17-ны өдөр баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэх зорилгоор МУЗГ-ын 2021.10.13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хүчингүй болгосон тул тус арга хэмжээг хасаж 16 арга хэмжээнд хяналт-шинжилгээг хийв.

Тус бодлогод тусгагдсан 16 арга хэмжээний **2025 оны эхний 8 сарын байдлаарх хэрэгжилтийн явц 80.3 хувь**, хяналт-шинжилгээ, үнэлгээний **шалгуур үзүүлэлтийн биелэлт 100 хувь** гэж тус тус үнэлэгдэв.

Үйл ажиллагааны хэрэгжилт

№	Зорилт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт
1	2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.	2.5.4.Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.	100%
2		2.5.9.Сайжруулсан түлш, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлж, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.	100%
3	4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.	4.2.1.Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.	100%
4		4.2.34.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.	100%
5		4.2.35.Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна.	30%
6		4.2.36.Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна.	100%
7		4.2.37.Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх, гадагш урсгалтай гол, мөрний урсцын 10 хувийг эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад хэрэгцээнд ашиглана.	100%

8		4.2.38.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн орчин үеийн дэвшилтэт технологийг түшиглэн орон нутгийн дулаан хангамжид ашиглана.	60%
9		4.2.39.Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дулааны эх үүсвэр, дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийнэ.	76.5%
10		4.2.40.Зүүн хойд азийн орнуудтай хамтран азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгыг хэрэгжүүлнэ.	100%
11		4.2.41.Эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, ухаалаг технологийг нэвтрүүлж, санхүүгийн бие даасан, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.	100%
12		4.2.42.Эх үүсвэрийн чадлын баланстэй уялдуулан нар, салхи, ус, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглана.	98.2%
13	5.3. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.	5.3.21. Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига үүсэх эрсдэлээс хамгаална.	100%
14		5.3.22. Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.	100%
15	9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.	9.3.36. Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.	ү/б
16		9.3.37. Нийслэлийн алслагдсан бүсүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий оргил ачааллын үед ажиллах хэсэгчилсэн, бие даасан дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулан төвлөрсөн дулаан хангамжийн системд холбож, үр ашгийг дээшлүүлнэ.	10%
17		9.3.47. Хот дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжид холбон сэргээгдэх эрчим хүчийг ашиглана.	10%
Нийт			80.3%

ДҮГНЭЛТ

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Эрчим хүчний яамны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээний **2025 оны эхний 8 сарын байдлаарх хэрэгжилтийн явц 80.3 хувь**, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн биелэлт **100 хувь** гэж тус тус үнэлэгдэв.

ЗӨВЛӨМЖ

Цаашид төсөл, арга хэмжээнүүдийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, суурь түвшинг бодитойгоор тодорхойлж, үе шат бүрт хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тэдгээрт харгалзах гүйцэтгэлийн хувийг төлөвлөж байх шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2025 оны 09 дугаар сарын 29-ний өдөр